

С. Янжинсүрэн

Шашин Судлалын
тэнхимийн багш, (Ph. D)ИНДУИЗМ¹

Түлхүүр үг: Вэд, вэд судрууд, каст, Брахма, Вишну, Шива, бурхан тэнгэрс, пуран судрууд

Эртний түүх, соёлт Энэтхэг улсад шашны олон янзын хэлбэр түгэн дэлгэрсэн ч тэдгээрийн дотор индуист шашин зонхилох байрыг эзэлж иржээ.

Дэлхийн нийт хүн амын 16% буюу 6 хүн тутмын нэг нь энэтхэг хүн нь энэтхэг хүн байдгаа ба тэдний 82%² индуизмийг шүтдэг нь индуист шашин хэр том хэмжээний шашин болох хийгээд Энэтхэг орны түүх, соёл, ард олны аж амьдралд ямар их нөлөө бүхий болохыг харуулж байна.

Энэтхэгчүүдийн хоол хүнс, хувцас, гэрлэх ёслол ер амьдралын өдөр тутмын үйл ажиллагаа бүр нь шашинаар зохицуулагдаж байдгаараа ихээхэн өвөрмөц юм.

Индуизм гэдэг нь мусулманы байлдан дагуулагчид өөрсдийн сүсэг бишрэлээс ялгахыг эрмэлзэж, МЭ-ний 1200 оны үед өгсөн нэр томъёо гэж үзэх бөгөөд энэ нь перс хэлний "энэтхэг" гэдэг үгтэй адил утгатай юм.

**Индуизмийн
үүсэл ба
Варна**

Индуист шашны түүхэнд түүнийг үндэслэгчийн тухай асуудал их бүрхэг, өнөөг хүртэл индуизмын талаарх судалгаанд түүний үндэслэгчийн талаар өгүүлсэн нь үгүй. Ер нь Индуизмыг соёл хэмээн үзэх нь ч буй.³ Индуист шашны үүсэл өнө эртний соёлт энэтхэгийн буурал түүх, иргэншлийн үр дүн мөн ажгуу. Энэтхэгийн соёл иргэншлийн 4000 орчим жилийн түүх түүний дотор индуист шашин оюуны өмнө ари үндэстэнтэй салшгүй холбоотой.

Одоогоос 3500 орчим жилийн тэртээ санскрит хэлээр бол дээдэс, газрын эзэд буюу аричууд гэх цайвар царайт хүмүүс Төв Азиас нүүдэллэн Энэтхэгт ирж нутаг орныг нь эзэлснээр энэтхэгийн хүн ам индо ари \indo-aryan\ хийгээд дравидиан \dravi-dian\ гэсэн хоёр том бүлэгт хуваагджээ. Аричууд Энэтхэгийн хойд хэсгийн хүн ардын өвөг дээдэс болж харин дравидианчууд өмнө зүгийн нутгийн бараан арьст ард олны элэнц хуланц болсон байна.

Аричууд нүүдэллэн ирж өөрсдийн амьдрал, аж ахуйг хөтлөн явуулах арга замыг нийгмийн хөрсөнд суулгаснаар нэн эртний

¹ ARC төслийн хүрээнд гүйцэтгэв.

² Sumit Ganguly, The Crisis of Indian Secularism, Journal of Democracy, pp 11-12, Volume 14, No 4, Oct. 2003.

³ Религий мира. Перевод с английского, Белфакс, М, 1994

энэтхэгийн соёл иргэншил дуусгавар болж энэ үеэс хүмүүсийг ялгаж, анги бүлэгт хувааж эхэлжээ. Учир нь тэд өөрсдийгөө нутгийн бараан арьст уугуул иргэдээс ялгах, улмаар тэднээс нийгмийн харилцааны бүх хэлбэрээрээ ялгарахыг оролдож байжээ. Тийм ч учраас янз бүрийн дэг жаяг, хууль дүрмийг бий болгож ягштал баримтлах болсон ба энэ нь үндсэндээ өнөөгийн энэтхэгийн зан заншил, шашин шүтлэг үүсэж бүрэлдэх нийгэм түүхийн нөхцөл болж өгсөн юм.

Индүист шашиныг даган бишрэгчийг хиндү гэх ба тэд өөрсдийн шашин шүтлэгтээ тулгуурлаж нийгмийн дөрвөн үндсэн бүлэг каст /caste-язгуур угсаа/ буюу варна \varna\ -д⁴ хуваагдана. Үүнд: брахмана \Brahmana-нийгмийн боловсролтой хэсэг болсон лам, философичид, эрдэмтэн мэргэд, шашины удирдах мяндагтангууд/, кшатрия \kṣatriya-цэргийн тушаалтан, цолтнууд, нийгмийн зүтгэлтнүүд, улс төрчид/, вайшя \vaishya -худалдаачид, тариачид/, шудра \śhūdra-ажилчид болон боол зарц\ нар байна. Тэрчлэн ямар ч варнагүй буюу ангигүй хүмүүс байх бөгөөд тэднийг париах \pariah-үл холбогдогч\ гэх ба тэд энэтхэгийн хүн амын 15 хувийг эзэлдэг байв. Чингэж хүмүүсийг нийгмийн бүлгүүдэд хуваасан нь тэднийг насан туршид нь зааглаж ялгасан зан заншил, ёс суртахуун, нийгмийн хил хязгаарыг үүсгэсэн төдийгүй ямар варнад байхаас шалтгаалан тэдний нийгэмд эзлэх байр суурь тодорхойлогддог байсан. Тухайлбал, варнагаа хэн бээр ч сольж үл болох бөгөөд дээд дээд бүлгийн хүн ард доод доод бүлгийнхний бэлтгэсэн хоол ундаанаас хүртэхийг цээрлэх, аль болох өөрөөсөө дээд варнагийн хүний бэлтгэсэн хоол хүнсийг хэрэглэх, хоёр өөр варнагийн хүмүүс хоорондоо эс гэрлэх, зарим нэгэн хүнсний бүтээгдэхүүнийг хориглох⁵ зэрэг болно.

Дөрвөн үндсэн варна нь дэд бүлгүүдэд, тэр нь цаашаа бичил бүлэг болон задардаг. Өөрөөр хэлбэл энэтхэгийн хүн амыг тоо томшгүй олон кастад хуваадаг бөгөөд тэдний зарим нь газар нутгийн хуваарийн дагуу хийгдсэн нь ч буй. Тухайлбал, брахманчууд л гэхэд оршин суугаа нутаг орноосоо хамаарч гурав, дөрвөн дэд бүлэгт хуваагдаж тэр нь цааш хорин бичил бүлэг болно. Кшатрия болон Вайши нар дэд болон бичил бүлгүүдэд хуваагддаг боловч хамгийн олон бичил бүлэгт хуваагддаг нь шудра нар болно. Тэд 18 дэд бүлэг, 108 бичил бүлэгт хуваагдаж ихэнхдээ оршин суугаа нутгийнх нь нэрээр бүлгийг нэрлэнэ⁶.

Ингэж нийгмийн гишүүдийн хоорондын харилцааг хааж байсан нь варна тус бүрийг өөрийн гэсэн биеэ авч явах байдал, хүмүүжил, амьдралын дүрэм горим бий болох, цаашилбал өв уламжлалтай болох, тэрдгээр нь үеэс үед хатуу баримтлах бичигдээгүй хуультай

⁴ Энэ нь өнгө гэсэн утгыг илэрхийлэхээс гадна язгуур гэх бас нэг утга буй хэдий ч аль аль нь дээрх утгад нийцнэ

⁵ Заримд нь махыг, заримд нь өндөгийг, заримд нь загас идэхийг хориглоно.

⁶ Abbe J. A. Dubbois, Hindu manners, customs and ceremonies, III ed, pp 16-17, New Delhi, 1999.

болоход хүргэсэн юм. Мянга мянган жил оршсоор ирсэн энэ бичигдээгүй хуулийг 1950 оны Энэтхэгийн үндсэн хууль халсан бөгөөд ялангуяа кастгүй хүмүүсийг нийгмийн харилцаанд идэвхитэй бөгөөд бусад варнатай адил тэгш оролцуулах болжээ.

Индүист шашин бол Эрхэт тэнгэрийг шүтэх шүтлэг мөн бөгөөд Энэтхэгийн ангит нийгмийн тогтоц, тухайлбал кастын хатуу системийг өмгөөлөн хамгаалагч болж ирсэн байна.

Индүист шашны үзэл номлол, зан үйл нь Энэтхэгийн төдийгүй, хүн төрөлхтөний гүн ухааны сэтгэлгээний нэгэн эх сурвалж болсон вэдийн судартай салшгүй холбоотой юм.

Вэдийн дуулал

Вэд гэдэг нь мэдлэг, ариун сургаал гэсэн утгатай үг. Эртний Энэтхэгийн шашин хийгээд философи сэтгэлгээний аман уламжлалт бүтээлүүдийг нэгтгэсэн нь вэд судар юм. Эл судар бас уран зохиол хийгээд түүхийн эх сурвалжид зүй ёсоор орно.

Вэд сударын зохогч нь хэн нэгэн тодорхой хүн бус бөгөөд энэтхэгийн ард түмэн тэнгэр бурханаас хүмүүст айлдсан сургаал-бэлэг гэж ихэд хүндэтгэдэг, эсвэл ерөөсөө өөрөө буй болсон зүйл, яг л галаас утаа гардаг шиг хэмээж шүтэн биширдэг. Харин тэдгээрийг үзмэрч Вьяса (Vyasa) ариутган шүүж, эмх цэгцэнд оруулжээ⁷. Хэдий тийм ч вэдийн судар нь ганц нэгэн хүний бүтээл бус олон арван сэтгэгчдийн хамтын бүтээл гэдэг нь ойлгомжтой юм.

Вэд нь Ригвэд (Rig-Veda), Яжурвэд (Yajur-Veda), Самавэд (Sama-Veda), Атхарвавэд (Atharva-Veda) гэх ялгаатай он цагт үүссэн дөрвөн үндсэн шастараас тогтох ба тэдгээр тус бүр нь Самхита (Samhitā), Брахмана (Brahmāna) гэсэн хоёр үндсэн хэсэгтэй байна. Самхита нь яруу найргийн хэлбэрээр, брахмана нь үргэлжилсэн үгийн хэлбэрээр бичигдсэн. Самхита гэдэг нь санскрит хэлний цуглуулга, эмхтгэл гэсэн утгатай үг бөгөөд тэнд магтаал дууллын цуглуулга байдаг болно. Тиймээс Ригвэд самхита, Яжурвэд самхита, Самавэд самхита, Атхарвавэд самхита гэж нэрлээд вэдийн дууллууд гэдэг.

Эхний самхита нь 10580 бадаг 1017 дууллаас, удаахи нь 1549 бадгаас бүрддэг ч түүний зөвхөн 78-аас бусад нь Ригвэдийн дуулал шүлэгтэй адил байдаг. Эдгээр дуулал бүр нэг нэг бурханд зориулагдсан байдаг тул зөвхөн нэг вэдийн дуулалд хичнээн бурхан тэнгэрс дурдагдах нь ойлгомжтой юм.

Яжурвэдийн дуулал дотроо хар, цагаан гэж ялгарах ба хар нь үргэлжилсэн үг хийгээд яруу найргийн хэлбэрийн аль алинаар бичигдсэн байдаг төдийгүй өөр өөр самхитануудад янз бүрийн өгүүлэмж шүлгээр орсон тул холимиг, замбараагүй хэмээдэг. Түүний шүлэглэн бичсэн хэсэг нь шашны зан үйл, тайлга ёслолын үед уншихад зориулсан тарни, үргэлжилсэн үгээр бичсэн нь уг тарнийн

⁷ W. J. Wilkins. Hindu Mythology, p 3, New Delhi, 1991.

шашны тайлбар ажээ. Харин цагаан нь түүнээс арай хожуу үед утга агуулгын хувьд дотроо зөрчил багатай, яруу найргийн хэлбэрээр дагнан бичигдсэн тарни юм. Яжурвэдийн дуулал нь Ригвэдийн дуулалтай давхацдаг, өөрөөр хэлбэл түүн дэх бүх өгүүлэмж бүхэлдээ Ригвэдээс эхтэй байдаг болой.

Атхарвавэд самхита 760 дуулалтай хийгээд зөвхөн YI дуулал нь л Ригвэдээс авсан байдаг ба түүнийг "вэдийн тарнийн утга зохиолын" бие гишүүнийг бүрдүүлсэн зохиол гэж үздэг юм байна⁸.

Эдгээр дууллын эмхтгэл А.Т.Ө 1500 оны үед бичигдэж а.т.ө 1000-800 онд брахмануудыг тэдгээрт тайлбар болгож туурвисан самхитанууд дахь шашны зан үйлийн заавар юм. Энэ тайлбарууд голдуу Веданта буюу "Ведийн төгсгөл" гэх нэрийн дор гарсан бөгөөд Веданта философийн үндсэн эх сурвалж болдог. Брахмана бүрд Упанишадыг⁹ \Upanishad\ хавсаргаж тэр нь илүүтэйгээр оюун ухаанаа төгөлдөржүүлэгч, сэтгэгч хэсэгт зориулсан, гүн ухааны агуулгатай. Веданта судар Упанишадад тааралдана.

Бас үүнээс гадна дияанчдад зориулсан Араньяка \Āranyaka\ гэсэн хэсэг байх бөгөөд эл хэсэг Упанишад бий болох үндсэн нөхцөл болсон байна. Араньяка буюу "Ойн судар" бол бясалгал хийж оюунаа дасгалжуулах, төгөлдөржүүлэхэд зориулсан шашны тахилгын нууц зан үйлийн эмхтгэл юм. Нийтэд бус, зөвхөн ой хөвчид амьдардаг бясалгалч нарт зориулсан учир түүн дэх зан үйлийг олны нүднээс далд ой хөвчид нууц байдалд үйлддэг байсан байж болох талтай. Ер нь бол Араньяка хийгээд Упанишад нь Брахманад хожуу үед нэмж хавсаргасан гүн ухааны бүтээлүүд мөн юм. Эндээс вэдийн шастаруудыг тус бүр нь Самхита, Брахмана, Упанишад, Арянака хэмээх дөрвөн хэсгээс тогтоно гэдэг. Тэдгээр нь энэтхэгийн нийгмийн дээд анги брахманчуудад, нэг үгээр хэлбэл аричуудад зориулагдсан "ариун сургаал" юм.

Гэтэл зарим судалгаанд үзэхдээ ведийн судрууд нь агуулга, түүний илэрхийлэл, зохиогдсон цаг хугацаагаараа ялгаатай дараахь гурван хэсгээс тогтоно гэж үзээд, үүнд: Самхита /төрөл бүрийн магтаал, дууллын цуглуулга/, Брахмана /зан үйлийн тайлбар, зураглал/, сутра \Sūtra-гарын авлага\ буюу нууц, гүн ухааны сургаалыг хавсаргасан гэж тайлбарлах нь ч бий¹⁰. Энэ бүхэн бол бид үндсэн эх сурвалжид өөрт нь тулгуурлах ёстой болохыг харуулж байна.

А.Т.Ө. ХҮ зууны үед бичигдсэн вэдийн дээрх судрууд бидний үед бүрэн эхээрээ хадгалагдан ирсэнгүй, амаас ам дамжсаар хожим нь бичигт буужээ. Хамгийн эртнийхэд Ригвэд самхита ордог бол Атхарвавэд самхита нь хамгийн сүүлд бичигдсэн залуу эх

⁸ The Encyclopedia of Eastern Philosophy and Religion, p 298, Boston, 1994.

⁹ Upanishad гэдэг нь дэргэд нь суух гэсэн утгатай санскрит үг бөгөөд номлол сургаалд хэн багшийнхаа дэргэд суусан нь түүнийг сайн сонсож авдаг байсан ба зарим нэгэн нууц сургалтанд тэд л оролцдог байжээ.

¹⁰ The Encyclopedia of Eastern Philosophy and Religion., p 403, Boston., 1994.

сурвалжид ордог хэдий ч энэтхэгийн анхны хууль зүй төрт ёсны сэтгэлгээний эх сурвалж болсон Ману судар энэ вэдээс даруй 200-300 жилийн дараа бичигдсэн ажээ.

Бусад хоёр вэдийг Ригвэд сударт түшиглэж туурвисан гэж үздэг учраас Ригвэд, Атхарваведээг бие даасан эх сурвалжууд гэж үзэж аливаа мэдлэг ухааны эх сурвалж болгох нь илүүтэй байдаг.

Ригвэд, Атхарвавед хоёрын агуулгаас үзэхэд тухайн үе бүрийн хүмүүсийн шашин шүтлэгийн байдал эрс ялгаатай байгаа нь ажиглагдана. Ригвэдийн үед хүмүүсийн шүтлэг бишрэл гэнэн сэтгэлгээнд суурилсан мухар сүсэг бишрэлийн хэлбэрт оршиж байсан бол Атхарваведийн үе болж ирэхэд энэтхэгчүүд өөрсдийн шүтээний дүр төрхийг нэлээд нэгдмэл, сүрлэг, хүчирхэг байдалтайгаар ямар нэг хүн амьтны дүрээр дүрслэх болсон байна. Тиймээс эл хоёр судрыг бие даасан эх сурвалж гэж үзнэ. Харин Ригвэд, Яжурвэд, Самаведүүд нэг гаралтай ч доторхи самхитагийн өвөрмөц онцлогоос тухайн ведийн нэр хийгээд агуулга нь тодорхойлогддог.

Хэрвээ Самхита чанга дуугаар уншихад зориулагдсан яруу найргийн хэлбэрээр бичигдсэн магтаалуудаас буюу Рич (Rich)-үүдээс бүрдэж байвал тэр нь Ригвэдийнх бөгөөд эндээс эл вэдийн нэр гарсан хэмээнэ. Хэрвээ үргэлжилсэн үгээр бичигдсэн тахилгуудаас буюу Яжус (Yajus)-уудаас бүрдсэн бол Яжурвэдийнх бөгөөд түүний нэр эндээс гарсан гэнэ. Нэг үгээр хэлбэл Яжурвэдийн онцлог нь дан тахилгаас бүрддэг юм. Хэрвээ яруу найргийн хэлбэрээр бичигдсэн бөгөөд аялгуулан дуулахад зориулсан магтаалаас буюу Сама (Sāma)-нуудаас бүрдсэн байвал Самавед хэмээдэг. Ер нь Вэдийн самхита буюу магтаал, дууллын цуглуулга нь олон хувилбартай байсан, үүнд Ригвэдийн 21, Яжурвэдийн 42, Самавэдийн 12, Атхарвавэдийн 12 хувилбар самхита байжээ. Эдгээр хувилбаруудын агуулга нь ижил, харин утга санааг илэрхийлсэн арга, шүлэглэл нь өөр өөр байсан бололтой. Хэрвээ хойно гарсан хувилбар өмнөхийнхөө утгаас зөрж байвал урд байсан хуучин хувилбарын утгыг үнэнд тооцож, хожуу үеийн хувилбарыг няцаадаг, нэг үгээр хэлбэл вэд биш гэж үздэг байсан тухай судалгаануудад олонтаа дурдсан байна¹¹. Ер вэдийг үнэний шалгуур болгодог байсан нь нийгмийн дээд анги, оюун санааны амьдралыг тодорхойлогч, вэдийг бүтээсэн аричуудад ихээхэн ач холбогдолтой, бас бусдаас ялгарах оюун санааны гол хэрэгсэл нь байсан бололтой юм.

Вэдийн дээрх хувилбаруудаас Ригвэдийн 1, Яжурвэдийн 3, Самавэдийн 2, Атхарвавэдийн ганц хувилбар самхита бидний үед хүрч ирсэн юм байна. Энэ бүхэн бол энэтхэгийн зонхилох шашин индуизмын оюун санааны эх сурвалж мөн болно.

¹¹ W. J. Wilkins. *Hindu mythology*, reprint, New Delhi., 1991.

Үүнээс гадна Рамаяна \Rāmāyana\ буюу “Рамын түүх”, Пурана \Purāṇa\ буюу “Эртний түүх”, \Mahābhārata\ буюу “Бхаратын хойч үеийн тууль”, түүний нэгэн хэсэг болох Бхарвадгита \Bhagavad Gītā\ буюу “Эрхэт тэнгэрийн дуулал” зэрэг индуист шашины үзэл санааны олон эх сурвалж байдаг байна.

Вэд судар гол сурвалж нь болж буй индүист шашны үзэл онол нь брахман тэнгэр бүхнийг бүтээсэн, бүхнээс анхдагч гэж үзэх үзэлд суурилдаг. Тиймээс орчлон ертөнцийн юмс, үзэгдэл бүрийг ямар нэгэн бурхан тэнгэрт хариуцуулж, хамаатуулж төсөөлдөг төдийгүй амьдралын гол утга учир нь вэдийн сударт гарч буй ёс зүйн хэм хэмжээг биелүүлэх, үнэнч шударга байх явдал хэмээн үзэхийн зэрэгцээ вэд судрыг үнэний гол шалгуур болгодог байна.

**Хиндү
шүтээн
түүний
хэлбэрүүд**

Эртний энэтхэгийн шашин, гүн ухааны зохиолуудын өгүүлэмж нь ихэнхдээ дайн дажны тухай байх ба тэнд авран тэтгэгч бурхад, тэнгэрс, сөнөөн сүйтгэгч чөтгөр шуламын тухай элбэг гардаг. Бурхан тэнгэрсийг магтан дуулж аврал эрснээр ивээлийг нь авч чөтгөр шулмасын

хорлолыг хариулдаг тухай өгүүлэмж ихэнх нь байна. Энэ өгүүлэмжид тулгуурлан энэтхэгийн шүтлэг бишрэлийг Вэдийн үеийн шүтээн, Пураны үеийн шүтээн, дордсын шүтээн гэж ялгаж үзнэ¹².

Вэдийн үеийн шүтээнд голчлон байгалийн эерэг юмс, үзэгдлийг ивээж байдаг, эсвэл сөрөг юмс, үзэгдлийг хааж саатуулж байдаг бурхан тэнгэрс орно. Тэдгээрийг газрын дээрх шүтээн буюу Агни \Āgni\, агаар мандлын шүтээн буюу Индра \Indra\, тэнгэрийн шүтээн буюу Суря \Surya\ гэж ялгана. Индуизмд 3-ын тоог ихэд бэлэгдэх ба Ригведэд газрын 11, агаар мандлын 11, тэнгэрийн 11 нийт 33 шүтээний тухай өгүүлдэг. Зарим вэдийн хувилбарт 300, 333, 3000 шүтээний тухай өгүүлэх нь ч буй. Эдгээрээс гадна аричуудын эртний шүтээн болох тэнгэрийн төлөөлөл Дяус \Dyaus\, газрын төлөөлөл болох Притиви \Prithivi\, бүх тэнгэр бурхадын эх Адити \Aditi\ болон түүний олон хувилбарууд \ митра-Mitra, Арьямануна-Aryamanuna, Дакша-Daksha, Амса-Amsa, Бхара-Bhaga, Варуна-Varuna эдгээрийг нийтэд нь адитя-Āditya гэх\, нар болон гэрлийн бурхан тэнгэрс болох Сурья \Sūrya\, Пушан \Pushan\, Митра \Mitra\, Варуна \Varuna\, Ашвин \Asvin\, Уша \Usha\, салхи шуурганы эзэн Индра \Indra\ түүний хувилбарууд: Индрани \Indrāni\, Паржаня \Parjanya\, Вааю \Vāyu\, Марут \Marut\, идээ ундааг ивээгч Сома \Soma\, дарх урлалын бурхан тэнгэр Твастри \Tvastri\ буюу сүүлийн үед Висвакарма \Visvakarma\ гэх, үл үзэгдэгч ертөнцийг ивээгч Яма \Yama\ зэрэг бурхан тэнгэрс тэдний олон хувилбарууд вэдэд гардаг. Тэд тус бүрдээ байгалийн тодорхой тодорхой үзэгдлийг хариуцан хүмүүсийн хүсэл эгээрлийг хангах учиртай нь харагдаж байна.

¹² Мөн тэнд

Тухайлбал, Сурья нь нар, нарны гэрэл гэгээг дэмжиж улмаар хүн ардад халуун дулаан уур амьсгал, үржил шим, хөгжил дэвшлийг бэлэглэдэг бол Твастригийн охин, Саранягийн хүү Яма нь шүүгч буюу далд юмсыг мэдэгч хаан юм. Тэрээр эхийн хэвлийд заяахдаа хоёр хүйсийн¹³ аль алиныг өөртөө шингээсэн бөгөөд хүмүүсийг нас барахад тэдэнд хойд насны хөтөч нь болдог ба тэр нас барагсдыг хаана аваачна тэд тэндээ үүрд үлддэг гэнэ.

Агни бол вэдийн дууллуудад хүндтэй байр эзэлдэг шүтээнүүдийн нэг. Тэр нь галын бурхан тэнгэр бөгөөд түүнд олон янзын дүр хувирал, нэр алдар¹⁴ байдаг шигээ олон янзын үүрэгтэй. Тухайлбал түүнийг 7 гэрэл цацарсан алтлаг биетэй, 3 толгойтой, буржгар үстэй, ам шүднүүд нь бүхнийг шатаан залгиж байдаг, гялалзсан эвэртэй, салхин хөөрөгтэй, улаан морь унасан байдаг гэж ихэнхдээ дүрсэлдэг. Бас 3 хөл, 7 гартай, хар нүд, хөмсөг, үстэй, жимсний хэлхээгээр биеэ чимж хуц унасан, амнаас нь гал бадарсан, улаан өнгөт эр хүний дүрээр дүрслэх нь ч буй. Тэрээр мөнх настай, ихэд мэргэн бөгөөд шашины зан үйлийг үйлдэх үед алдаа эндэгдэл гарахаас сэргийлж бурхан тэнгэрст үйлчилж байгаа эрсэд тусалдаг, газар тэнгэрийн зууч юм. Агни эр хүний эзэн нь, хамгаалагч нь, хаан нь мөн. Тэр бол гал асаасан айл, байр орон бүрийн эзэн, айл бүрд байдаг. Тэрээр эртнээс өнөөг хүртэл хүний бурхан тэнгэрт хандан үйлдэж байгаа үйлийн гэрч, хуримын үед ч, үхлийн үед ч байна гэж үздэг. Нэг үгээр хэлбэл энэтхэгчүүд хурим хийхдээ, бас нас барагсдыг оршуулахдаа ямар нэг байдлаар галтай холбоотой шашны зан үйл үйлддэг байна.

Индра бол чин шударга сэтгэлтийг ивээгч, аливааг биелүүлж хэрэгжүүлэхэд дэм тус үзүүлэгч, үржил шимийг тэтгэгч болно. Агаар мандлын эзэн бөгөөд бороо оруулж, аянга цахилгаан буулгадаг, бас салхины эзэн. Вэдийн дууллын нэлээд олон шүлэг түүнд зориулагдсан байдаг бөгөөд үүгээрээ Агнигийн дараахь байр суурийг эзэлдэг. Тэрээр ихэнхдээ эр хүний дүрээр дүслэгдэх ба 4 гартай, 2 нь жад барьсан, 3 дахь нь аянга атгасан, 4 дэх нь хоосон байдаг. Аянга бол түүний гол зэвсэг болно. Заримдаа түүнийг 2 гартай, биеэрээ дүүрэн нүдтэй дүрслээд "Мянган нүдэт" буюу Шахасракша \Sahasrāksha\ гэж нэрэлнэ.

Вэдэд наранд зориулсан бүхнийг Сурьяа эсвэл Савитри \Savitri\ гэдэг нэрийн дор илэрхийлнэ. Савитри гэдэг нь нарыг хүний нүдэнд үзэгдэхгүй байгаа үед тухайлбал бүрхэг үед, Сурьяа нь нарыг нүдэнд илт харагдан ахуй агшинд төлөөлнө. Гэхдээ эдгээр нэрсийг зарим үед хүндэтгэлийн утгаар хэрэглэх хэдий ч утга нь хоорондоо солигдох, эсвэл бүүр хоёр өөр зүйлийг илэрхийлэх тохиолдол байна. Энэ бол энэтхэгийн нутаг уудам, хүн ам өнөр

¹³ W. J. Wilkins, *Hindu Mythology*, p 79, repr, New Delhi, 1991.

¹⁴ Vahni-тахил өргөгч, Vitihotra-шүтлэгтэнээр техил өргөгч, Dhananjaya-баялаг шатаагч, Jivalana-шатагч, Dhūmketu-утаан мөрт, Chhāgaratha-хуцан унаат, Saptajivha-долоон хэлт гэх мэт.

түүндээ үндэслээд нутаг нутгийн шашны ойлголт, зан заншил өөр өөр байдагтай холбоотой бололтой юм. Гэвч үндсэн агуулга нэг гэдэг нь ойлгомжтой.

Сурьяа бол Адитигийн хүү, Ушас бол түүний эхнэр. Ер нь индуист шашны бурхан тэнгэрс бүгд хоорондоо холбоо хамааралтай, нэг нэгийнхээ хүү, охин, эх, эцэг байдаг.

Савитри нь алтан нүдтэй, алтан гартай, алтан хэлтэй шүтээн. Тэрээр гэрэл цацарсан, цагаан хөлт морь хөлөглөж өрөөсөн алтан гараа адистидлах адил сунгасан нь энэ дэлхийг гэрлээр гийгүүлж, бүх шим ертөнцийг сайн энергээр хангах бэлгэдлийг агуулна. Савитри тэнгэрийн хаан хийгээд бусад тэнгэрийн бурхан тэнгэрс Савитрийн зарлиг тогтоолыг дагах ба тэр тэдгээрт мөнхийн шинжийг бэлэглэдэг. Савитри бээр нүглээс ангижирсан бүхний төлөө залбирдаг хэмээн вэдэд үздэг бол пураны үе болоход тэс өөр агуулгыг илэрхийлэх болсон байна. Бүүр гарал үүсэл нь өөрчлөгдөж Касяпа \Kasyapa\, Адити \Aditi\ нарын хүү хэмээгээд, гадаад төрхийн хувьд гэвэл 3 нүд, 4 мутартай, бараан улаан арьстай эр хүний дүрд хувилж, хоёр мутартаа усны сараана цэцэг барьж, нэгийгээ адис хайрлах мэт, нөгөөгөө шүтлэгтэн олныг дэмжих мэт дэлгэсэн байна. Тэр лянхуа цэцгийн голд заларч, гэрэл цацруулан байдаг. Бүх кастын хүмүүс дээр, доорын ялгалгүй жилд нэг удаа мөргөнө. Тэрээр хүмүүсийг өвчин эмгэгээс салахад тусална гэхчлэн бурхан тэнгэрс өөр өөр үед өөр өөр үүрэгтэй болсон нь индуизмийн нэгэн онцлог юм.

Пураны үеийн бурхан тэнгэрсийн дотор Брахма \Brahma\, Сарасвати \Sarasvati\, Вишнү \Vishnu\, Лакшми \Lakshmi\, Аватара \Avatāra\ түүний олон хувилбарууд, Шива \Shiva\, Ума \Uma\, Паарвати \Pārvati\, Дюргaa \Durgā\ түүний бусад хувилбар, Ганеш \Ganesa\, Картикея \Kartikeya\ зэрэг . . . чухал байр суурьтай байдаг.

Пуран гэдэг нь эртний ном, зохиол гэсэн утгатай үг бөгөөд энэ бол ведийн дараа эртний Энэтхэгт бий болсон бурхан тэнгэрсийн тухай баатарлаг туульс юм. Зөвхөн яруу найргийн хэлбэрээр бус, бас үргэлжилсэн үгээр бичигдсэн нь ч буй. Пуран нь Пурана \Purāna\, Упа-пурана \Upa-Purāna\ гэх хоёр хэсгээс бүрдэх ба Упа-пурана гэдэг нь “Хоёрдугаар пуран” гэсэн утгыг агуулна. Хоёулаа 18, 18 зохиолоос бүрдэнэ. Пуран нь дотроо зургаан Вайшнава пурана \Vaishnava-Purāna\, зургаан Шайва пурана \Shaiva-Purāna\, зургаан Брахмана пурана \Brāhmaṇa-Purāna\ гэж гурав ялгагдана¹⁵. Ингэж ялгахын учир нь Пуранд “Брахма” буюу энэ ертөнцийг бүтээгч, Вишнү буюу энэ ертөнцийг аврагч, Шива буюу энэ ертөнцийг

¹⁵ Зургаан Vaishnava-Purāna нь: Vishnu- Purāna, Bhāgavata- Purāna, Padma- Purāna, Nārada- Purāna, Garuda- Purāna, Varāha- Purāna, зургаан Shaiva-Purāna нь: Matsya- Purāna, Linga- Purāna, Skanda- Purāna, Kūrma- Purāna, Shiva- Purāna, Agni- Purāna заримдаа Vāyu- Purāna гэх, зургаан Brāhmaṇa-Purāna нь: Brahma- Purāna, Brahmapurāṇa- Purāna, Vāmana- Purāna, Brahmanāda- Purāna, Mārkaṇḍeya- Purāna, Bhaviṣya- Purāna болно.

сөнөөгчийн тухай домгийг голчлон өгүүлдэг. Ер нь Пуран судар индуист шашны итгэл бишрэлийн цөмийг агуулсан байдгаараа онцлог хийгээд тэдгээрийн дотроос хамгийн уламжлалаа хадгалсан, шашны итгэл бишрэлийг илэрхийлсэн нь Вишну пурана (Vishnu-Purāṇa), Бхагава пурана (Bhāgava-Purāṇa) болно. Пуранууд 5600-81000 хос шүлэглэлүүдээс бүтэх ба ихэнхдээ багш шавийн харилцан яриа хэлбэрээр бичигдсэн байдаг нь түүний бас нэг онцлог юм. Пуран бүр дараахь таван сэдвийг агуулсан байдаг нь тэдгээрийн удаахь онцлог гэлтэй. Үүнд: а) ертөнцийн үүсэл, түүнийг бүтээж байгаа тухай, б) ертөнцийг эвдлэн сүйтгэж дахин шинээр бий болгодог тухай, в) Бурхан тэнгэрсийн болоод домгийн баатруудын үүсэл гарлын тухай, г) хүний хөгжлийн янз бүрийн үе дэх Манугийн¹⁶ хэм хэмжээний тухай, д) хүний хойч үеийн ач үрсийн амьдрал бүтээлийн тухай тус тус өгүүлнэ.

Пуран судрууд бүхэлдээ индуист шашины нэвтэрхий толь юм гэж судлаачид үздэг. Одоо хэр эл судруудын агуулга өнөөгийн Энэтхэгийн нийгэм болон шашин дахь ёс зүйн гол хэм хэмжээний суурь болсоор байна. Өнөөдөр ч эл бүтээлүүдийг энэтхэгчүүд нийтээрээ уншсаар буй.

Нөгөө талаар Пуран судрууд энэтхэгийн домог зүйн эх үндэс болдог. Пуран бүхэлдээ А.Т. ҮШ зууны үед зохиогдсон гэж үздэг ч гэсэн түүн дэх зарим домог нэлээд эрт үеийнх байх нь ч буй. Тиймээс Пуран судруудыг зөвхөн вэдээс хойших үеийн энэтхэгийн шашин, нийгмийн асуудлуудыг домогчлон гаргасан гэж үзэх нь алдаа дутагдалтай болох буй за.

Пуран дахь Брахма, Вишн , Шива гурван шүтээнийг индуизмийн гурвал гэнэ. Тэдгээрээс гадна Брахма гэж байх бөгөөд энэ бол индуизмийн ойлголтоор эрхэт тэнгэрсийн дээд нь, тэдний бурхан тэнгэр нь юм. Тэрээр тэдгээр бурхадын байр байдал, үүрэг хариуцлагыг тодорхойлж өгсөн гэж үзнэ.

Брахма бол бүтээгч, бурхан тэнгэрс хийгээд хүн төрөлхтөний эцэг. Индуизмд түүнийг галуу унасан, таван нүүртэй, бараавтар улаан арьстай, цагаан өмсгөл асаасан, нэг гартаа таяг, нөгөө гартаа өглөг тоссон таваг барьсан эр хүний дүрээр дүрсэлдэг. Түүний таван толгойг дараахь байдлаар тайлбарлана. Үүнд: Брахма охин Сатарупа (Satarupā) -г төрөхөд түүнд ихэд хайр хүрч энхрийлжээ. Түүнийг өхөөрдөн харж байтал охин баруун талд нь гарсан тул охиныг араас нь харах хүсэл хоёр дахь толгойг буй болгосон гэнэ. Түүний харцаас далдирсан охин зүүн тийш, арагш хөдлөхөд дахин

¹⁶ Manu гэдэг нэр томъёо ямар эх сурвалжаасаа хамааран 2 утгыг илэрхийлдэг. Ведийн дууллууд дахь Manu нь хууль ёс, дүрэм журам, хууль тогтоогч гэсэн утгыг илтгэдэг бол Пуран судрууд дахь Manu нь хүн, хүний өвөг, оюун ухаант хүн, зарим үед оюун санаа гэсэн утгыг илтгэдэг.

Бас эртний энэтхэгийн анхны төрт ёсны сэтгэлгээний эх сурвалжийг Manu гэдэг тухай дурдсан буй. Уг эх нь 21 бүлэг 100 000 бадаг шүлэгтэй боловч хожим нь Nārada htbth vtmutux 12 000, Sumati хэмээгч 4 000 болгож хураасан боловч тэдгээрээс одоо зөвхөн 2 685 бадаг нь л хадгалагдан ирсэн байна.

хоёр толгой гарсан бөгөөд түүнээс зугтаасан охин тэнгэр рүү үсрэхэд дээш харах тав дахь толгой нэгэнт бий болсон гэж өгүүлнэ. Хүн, бурхан тэнгэр, чөтгөр, сайн муу заяаны амьтан бий болж бүгдийг хамтдаа бий болгоё л доо гэсэн Брахмагийн гуйлтыг сонсоод охин газарт буун ирж, олон олон жил хамтдаа амьдарсан гэж домогт гарна. Ингэж тэрээр бүхнийг бүтээсэн хэмээн индуизмд үздэг.

Вишнү бол Брахмагийн бүтээсэн бүхнийг хамгаалагч юм. Тиймээс Пураны олон судруудад Брахма, Вишнү бол миний нэгэн адил бүтээгч, хэрвээ миний бүтээснийг тэр сахин хамгаалаагүй бол тэд байхгүй байх байсан юм гэж Вишнүүг магтан дуулсан буй. Падмпурана (Padma-Purana) -д бичихдээ: Вишнү ертөнцийн бүтээгч, хамгаалагч, сөнөөгч нэгэн зэрэг байхыг хүсчээ. Гэтэл туйлын оюун санаа, сүнс биеийнхээ баруун талаас ертөнцийг бүтээгчтэй байх ёстой гээд Брахмааг, зүүн талаас түүний хамгаалагчтай байх ёстой гэж Вишнүүг, эцэстээ ертөнц устгах ёстой тул сөнөөгч болгож Шивааг тус тус төрүүлсэн байна¹⁷. Зарим хүмүүс Брахмааг, зарим нь Вишнүүг, зарим нь Шивааг шүтнэ. Эндээс брахманизм, вишнүизм, шиваизм аажимдаа үүсч, улмаар индуизмийн дотроос энэтхэгийн бусад олон шашин шүтлэг үүсч гарах нөхцлийг бүрдүүлсэн байна.

Шива бол индуизмийн гурвалын сүүлчийнх бөгөөд ертөнц нэгэнт бүтээгдсэн тул бас устгагдах ёстой гэж түүнийг бүтээсэн гэнэ. Индуизмд үзэхдээ үхнэ гэдэг бол зөвхөн нэг хэлбэрийн амьдралаас нөгөө хэлбэрийн амьдралд л шилжиж байгаа хэрэг. Энэ бол нэг оршихуйгаас нөгөө оршихуйд л шилжиж байгаа юм. Тэгэхээр сөнөөгч гэдэг бол "дахин бүтээгч" мөн, учир нь шинэ өөр хэлбэрийн оршихуйд тэр устгасан зүйлээ аваачсан хэрэг гэж үзнэ. Тиймээс Шива бурхан тэнгэрийг жинхэнэ сөнөөгч гэдэг утгаар биш харин ч түүнийг эерэгээр гэрэл гэгээтэй болгож, шүтэн биширдэг. Индуистүүдийн нийтлэг шүтдэг шүтээний нэг нь Шивагийн эхнэр гэгддэг Дюрга болно.

Энд дурдсан шүтээнүүд бүгдээрээ хүн төрхтэй боловч энэтхэгчүүд бас амьтан дүрт шүтээнийг шүтэн бишрэх нь элбэг байдаг.

**Сүм хийд,
баяр ёслол**

Индуистүүд тусгайлан барьж байгуулсан шашин шүтээний газартай байх ба түүнийг сүм гэнэ. Ихэнх сүм нь хэд хэдэн бунхантай байхаас гадна сүмийн гол шүтээнийг түүнд зориулсан тусгай бунханд залсан байхын зэрэгцээ гэр орондоо шүтлэгийн тусгай хэсэгтэй байна. Тэнд өөрсдийн шүтээнийг байрлуулаад идээ ундааны дээжээ өргөж, залбирал үйлддэг.

Үндэснийхээ томоохон баярын үед сүмдээ цугларч баяраа хийдэг. Ялангуяа Ганга мөрний эрэг дагасан сүмд очих дуртай. Учир нь тэд Ганга мөрнийг ертөнцийн хамгийн ариун, гэгээн устай мөрөн гэж үзэж угаал үйлдэхээс гадна нас барсан хойноо бас тэнд

¹⁷ W. J. Wilkins, *Hindu Mythology*, pp 118-119, repr, New Delhi, 1991.

шарилаа өргөх нь тэдний гол эрмэлзэл байна. Учир нь ариун ус ариун орон луу хөтөлдөг гэж үзнэ. Ганга мөрнийг шүтэх нь бас ч ахуй амьдралын гүн үндэстэй буюу. Энэтхэгийн халуун бүс нутгийн голлох аж ахуй нь хөдөө аж ахуй, газар тариалан байсан тул эрт үед тэдний хувьд ус хамгийн чухал байсан бололтой. Харин ус хэдийгээр чухал ч үер болох зэрэг усны аюул бас олон байсан буй за. Тухайлбал, Энэтхэгийн анхны соёл иргэншил усанд автаж үгүй болсон гэж түүхэнд тэмдэглэгджээ.

Энэтхэгийн газар нутаг хоёр талаараа их усаар хүрээлэгдсэн хойд талаараа Гималайн өндөр уулсаар хашигдсан, дүрс хэлбэрийн хувьд гурвалжиндуу, өөрөөр бас эмэгтэй хүн шиг хэлбэртэй гэж энэтхэгчүүд өөрсдөө үздэг. Тэр Энэтхэг-Эх гэх газар нутаг дээгүүр урсах гол мөрөн өргөн уудам тал нутгийг услаж, үржил шимийг хүртээж, арвин их ургац өгдөг тул ер нь усыг ихэд хүндэтгэж, ялангуяа дияанчдын хувьд бясалгал хийх хүчин зүйлийг бүрдүүлэгчийн нэг болдог юм гэж үзнэ. Харин Ганга мөрний тухайд бол тэрээр зөвхөн газар дэлхийг услаад зогсохгүй, эцэс төгсгөлгүй амьдралын бэлэг тэмдэг болдог юм. 12 жилд нэг удаа болдог "Кумбх мела" хэмээх баярын үеэр Ганга, Жумна мөрний цутгалан дээр бараг 10 сая хүн цугларч мөргөл хийдэг бөгөөд Ганга мөрний эрэг дээрх Варанаси хотыг хамгийн ариун дагшин газар хэмээн үздэг байна.

Энэтхэгийн түүхт хаад шашныг ихэд дэмждэг байж, тэд нэг талаас улсын хаан, нөгөө талаас бурхан тэнгэрийн хүүд тооцогддог байсан байна.

Индүизмд эмэгтэй бурхан тэнгэрс, Дара-эхс олон байх ба энэ нь бас ч эмэгтэй хүнд зарим талаар ихээхэн хүндэтгэлтэй ханддагийг илэрхийлнэ. Ялангуяа мөргөл үйлдэхдээ ихэнхдээ Дара-эхэд эхэлж мөргөх бөгөөд тэдний тухай дуулал, магтаал эртний түүхэн дурсгалт судруудад орсон нь цөөнгүй. Булш бунханы малтлагаас ч тийм Дара-эхсийн баримал, шуумал дүр арвин олддог.

Эртхэн үедээ индүизмд тайлгач нар нийгэмд ихээхэн нөлөөтэй байсан байна. Учир нь энэтхэгийн ард түмэн ёс заншлыг хатуу баримтлах сонирхолтой байдаг нь шашны зан үйлийг дэглэж хянадаг тахилгачдын хувьд нийгэмд чухал байр суурь эзлэх, бусдаар хүндлүүлэх, ард түмэн тэднийг сонсох таатай боломжийг олгосон гэж хэлж болно. Нэг ёсондоо тайлгачид хүмүүсийг бурхан тэнгэрстэй харьцах хөтөч, тэднийг холбох гүүр нь болохын зэрэгцээ харилцааг нь зохицуулж байдаг гэнэ.

Индүист шашинд Жайн болон Буддын шашин ихээхэн нөлөө үзүүлсэн байна. Жайны шашны "таван ариун үйл" индүист шашинд тэр чигээрээ орж ирж өнөөг болтол баримталсаар иржээ. Үүнд: аливаад хүч хэрэглэхгүй байх, үнэнч байх, шударга байх, ариун

байх, бие даасан хамааралгүй байх зэрэг болно. Үүнийг амьдралыг хүндлэх явдал ч гэж үзэх тал байдаг¹⁸.

Индүист шашинд гэр бүлийн ариун журамт, үнэнч байдлыг ихэд эрхэмлэнэ. Үнэнч шударга байдлыг эрхэмлэх болсон нь энэтхэгийн эртний түүх, уран зохиол, шашин, гүн ухааны эх сурвалж болсон Рамаяна /24 000 шүлэгтэй/ дуулалтай салшгүй холбоотой. Тэнд өгүүлэхээр бол, Рама хаан бусдын хатгалгаар хаан ширээгээ алдаж, хайртай хатан Ситагаа ч харийн оронд алдана. Үнэнч албатын бэлгэдэл болсон сармагчингуудын тусламжтайгаар хатан Ситагаа буцаан авах бөгөөд хатан нь Рамад үнэн сэтгэлээсээ хайртай, хэрвээ шаардлага гарвал Рамааг чандарлаж байгаа галд хамт орж шатахад ч бэлэн байдаг. Тиймээс Ситаг үнэнч, үлгэр жишээч гэргийн дүр болгож шүтнэ. Харин Рама бол шударга үнэний бэлгэдэл ба ерөөс энэ дууллыг ард түмэн өсөх бага наснаас үлгэр домог болгон сонсож, уншиж хожим нь өрх гэрийн амьдралын удирдамжаа болгодог байна. Рамаяана бол эртний эх сурвалжуудын дотроос хамгийн олон тайлбар зориулж бичсэн сурвалжид ордог. Энэ нь түүний агуулга олон талтай болохын нэг илрэл болно.

Индүист шашин политеист шашин боловч олон бурхадын дотроос зөвхөн нэг бурханыг онцолж шүтэх ёс ихэд дэлгэрсэн юм. Түүнийг индүизмд Бхагти гэдэг. Бхагтийг хөгжихөд Кришнагийн домог ихээхэн үүрэг гүйцэтгэсэн байна. Кришна тэнгэр хэдийгээр хаан хүү байсан боловч аймшигт үеэл эгч Камсагаас зугтахын эрхэнд Вирандабын малчдын дунд суурьшдаг. Тэр бишгүүр хөгжмөөр гайхалтай чадмаг тоглодог тул залуу охид, бүсгүйчүүдийн сэтгэлийг булаана. Кришна шүтэн бишрэгчдийхээ хувьд эцэг нь, ах нь, нөхөр амраг нь ч болох тохиолдол байна. Ер нь Кришнатай холбоотой эротик дүрслэлүүдийг тэрээр хүмүүст улам ойртож байгаагийн бэлгэдэл болгож ойлгодог.

Ингэж индүист шашины элементүүд ард түмний амьдрал, сэтгэл санаатай нягт холбогддог ба энэ нь түүнийг түүхийн урт удаан хугацааны туршид Энэтхэгийн ард түмний зонхилох шашин болох нэг шижим болсон гэлтэй юм.

HINDUISM

A key words; Veda, vedas, caste, Brahma, Vishnu, Shiva, gods, Puranas.

About 82 % of the Indian people are Hindus, and about 12% are Muslims. The next largest religious groups are in order of size, are Christians, Sikhs, Buddhists and Jains.

Hindus are divided into a large number of groups called castes. The castes are grouped into 4 main categories such as Brahmanas, kṣatriyas, vaishyas and, shūdras. Also one group of people, who is

¹⁸ . Религии мира., перевод с английского, стр 170-206, Белфакс, 1994.

existing out of social relations, called Pariah. Hindus worship many divinities. The three most important ones are Brahma, the creator of the universe; Vishnu, its prserver; and Shiva its destroyer.

Hinduism has a number of sucred writings that outline how is its followers should conduct their lives.

Ном зүй:

1. Sumit Ganguly, The Crisis of Indian Secularism, Journal of Democracy, Oct. 2003.
2. Религии мира., перевод с английского, Белфакс, М, 1994.
3. W. J. Wilkins, Hindy Mithology, repr, New Delhi, 1991.
4. The Encyclopedia of Eastern Philosophy and Religion, Boston., 1994.
5. Abbe J. A. Dubbois, Hindy manners, customs and ceremonies, III ed, New Delhi, 1999.
6. В. П. Каниткар, У. Оуэн Коул. Индуизм ., пер с англ. Е. Богдановой.-М, 1999
7. Народы и Религии Мира энцеклопедия, М, 1999
8. The Illustrated encyclopedia of World Religions, GB, 1997
9. World Book, encyclopedia series, USA, 1997